



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хутаг-Өндөр суман дахь Сум дундын ойн ангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2021/96/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2021 он</p>	<p>Газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70342315 Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Аудитор: Б.Энхтөр Утас: 70342716 Цахим хаяг: Enkhturb@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	8
3. Аудитын тайлан.....	8
3.1. Ерөнхий зүйл.....	8
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	9
3.4. Материаллаг байдал	10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	10
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	11
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	12
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.9. Аудитын илрүүлэлт.....	12
Залруулсан алдаа.....	Error! Bookmark not defined.
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	13
Аудитын зөвлөмж.....	13
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	13
4. Менежментийн захидал	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	15

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2021.02.25 № 02

танай _____-ны № _____ т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хутаг-Өндөр суман дахь Сум дундын ойн ангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хутаг-Өндөр суман дахь Сум дундын ойн ангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүс ч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

006020070

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



ДАНХБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>17,253,485.02</u>	<u>16,335,485.02</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	17,253,485.02	16,335,485.02
351	Түүхий эд материал	10,067,389.02	9,149,389.02
35110	Тусгай зориулалттай материал	10,067,389.02	9,149,389.02
354	Хангамжийн материал	7,186,096.00	7,186,096.00
35420	Аж ахуйн материал	1,101,140.00	1,101,140.00
35450	Барилгын засварын материал	5,964,956.00	5,964,956.00
35470	Бусад хангамжийн материал	120,000.00	120,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>10,343,943.47</u>	<u>6,606,751.38</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	10,343,943.47	6,606,751.38
392	Биет хөрөнгө	10,123,943.47	6,408,751.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,511,200.00	2,511,200.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-585,946.78	-627,800.14
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	5,644,000.00	4,334,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-5,644,000.00	-4,334,000.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,303,741.00	14,931,065.78
39208	Хуримтлагдсан элэгдэл	-18,531,400.75	-10,405,714.30
393	Биет бус хөрөнгө	220,000.00	198,000.04
39301	Програм хангамж	220,000.00	220,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-21,999.96
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>27,597,428.49</u>	<u>22,942,236.40</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>27,597,428.49</u>	<u>22,942,236.40</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	27,597,428.49	22,942,236.40
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,750,000.02	1,750,000.02
51101	Өмч: - төрийн	1,750,000.02	1,750,000.02
512	Хуримтлагдсан үр дүн	25,847,428.47	21,192,236.38
51210	Өмнөх үеийн үр дүн	25,847,428.47	25,847,428.47
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-4,655,192.09
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>27,597,428.49</u>	<u>22,942,236.40</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<u>59,206,775.33</u>	<u>73,591,881.16</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>19,947,775.33</u>	<u>35,354,281.16</u>
120	Нийтлэг татварын бус орлого	19,947,775.33	35,354,281.16
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	19,947,775.33	35,354,281.16

Хутаг-Өндөр суман дахь Сум дундын ойн ангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,566,824.53	30,852,925.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,380,950.80	4,501,356.16
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	39,259,000.00	38,237,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	29,299,000.00	38,237,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	29,299,000.00	38,237,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	68,280,219.30	75,051,006.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	68,280,219.30	75,051,006.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	58,533,277.30	59,609,988.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	37,482,100.00	43,988,120.47
210101	Үндсэн цалин	22,671,200.00	27,783,687.65
210102	Нэмэгдэл	4,941,900.00	16,204,432.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,685,200.00	5,488,036.00
210201	Тэтгэврийн даатгал	3,390,800.00	3,738,998.00
210202	Тэтгэмжийн даатгал	323,600.00	439,882.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	258,900.00	351,905.00
210204	Ажилгүйдлийн даатгал	64,700.00	87,976.00
210205	Эрүүл мэндийн даатгал	647,200.00	869,275.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,962,600.00	3,146,400.00
210401	Бичиг хэрэг	427,500.00	1,026,400.00
210402	Тээвэр, шатахуун	3,235,100.00	2,120,000.00
2105	Нормативт зардал	426,000.00	550,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	550,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,045,000.00	64,000.00
210702	Дотоод албан томилолт	1,045,000.00	64,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	294,700.00	412,950.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	101,900.00	208,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	48,000.00	108,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	71,500.00	63,750.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	15,000.00	33,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,633,993.30	5,960,481.91
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,864,493.30	5,960,481.91
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,746,942.00	15,441,018.53
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,980,942.00	15,441,018.53
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,980,942.00	15,441,018.53
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-9,073,443.97	-1,459,125.75
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	3,196,066.34
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	2,278,066.34
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	918,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-3,196,066.34
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-9,073,443.97	-4,655,192.09

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	69,704,040.00	69,090,525.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,087,722.00	30,852,925.00
120	Нийтлэг татварын бус орлого	19,087,722.00	30,852,925.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	19,087,722.00	30,852,925.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,087,722.00	30,852,925.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	50,616,318.00	38,237,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	29,299,000.00	38,237,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	29,299,000.00	38,237,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	69,484,040.00	69,090,525.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	69,484,040.00	69,090,525.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	59,737,098.00	53,649,506.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	38,854,724.00	43,988,120.47
210101	Үндсэн цалин	23,769,200.00	27,783,687.65
210102	Нэмэгдэл	4,941,900.00	16,204,432.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,685,200.00	5,488,036.00
210201	Тэтгэврийн даатгал	3,421,300.00	3,738,998.00
210202	Тэтгэмжийн даатгал	293,100.00	439,882.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	258,900.00	351,905.00
210204	Ажилгүйдлийн даатгал	64,700.00	87,976.00
210205	Эрүүл мэндийн даатгал	647,200.00	869,275.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,962,600.00	3,146,400.00
210401	Бичиг хэрэг	427,500.00	336,400.00
210402	Тээвэр, шатахуун	3,235,100.00	2,810,000.00
2105	Нормативт зардал	976,000.00	550,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	550,000.00	550,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,045,000.00	64,000.00
210702	Дотоод албан томилолт	1,045,000.00	64,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	294,700.00	412,950.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	101,900.00	208,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	48,000.00	108,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	71,500.00	63,750.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	15,000.00	33,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,746,942.00	15,441,018.53
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,980,942.00	15,441,018.53
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,980,942.00	15,441,018.53

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,750,000.02	00.00	25,847,428.47	00.00	27,597,428.49
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,750,000.02	00.00	25,847,428.47	00.00	27,597,428.49
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,750,000.02	00.00	25,847,428.47	00.00	27,597,428.49
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-4,655,192.09	00.00	-4,655,192.09
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,750,000.02	00.00	21,192,236.38	00.00	22,942,236.40

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	00.00	3,587,028.00
610002	Төсвөөс гадуур байгууллага	00.00	00.00	00.00	00.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	00.00	00.00	1,020.00	58,301.00
620001	Удирдах ажилтан	00.00	00.00	555.00	7,878.00
620002	Гүйцэтгэх ажилтан	00.00	00.00	455.00	4,545.00
620003	Үйлчлэх ажилтан	00.00	00.00	10.00	45,878.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант онд дээд газраас болон орон нутгаас нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хутаг-Өндөр суман дахь Сум дундын ойн ангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Г.Ганхуяг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд батлагдсан орон тоо, талбай тусгаарлалтын авлага, орлого бүрдүүлэлт зэрэг алдаа зөрчлийг дахин давтахгүй байх талаар зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дүгээр сарын 15-наас 2021 оны 02 дүгээр сарын 7-ны хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Энхтөр хариуцаж хэрэгжүүлэв.

Хутаг-Өндөр суман дахь Сум дундын ойн ангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 04 тоот дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

“Ойг ангийн үйл ажиллагааны үндсэн зорилт нь ойн баялгийг хамгаалах, тогтвортой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх нэгдсэн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэхэд нь мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, ойн санд учирсан хохирлын экологи эдийн засгийн үнэлгээ хийх, ойн хөнөөлт шавж өвчний голомтын тойм судалгаа хийж дүгнэлт гаргах, ойн төлөв байдалд үнэлгээ өгөх, ойн тооллого бүртгэл зохион байгуулалт, хортон шавж өвчний тэмцлийн явцад хяналт, шинжилгээ хийх, ойжуулалт, ОАА-н харга хэмжээ, ой ашиглалтын шинэ техник технологийг турших, нутагшуулах, хөтөлбөр төсөл хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулах, бүх нийтээр мод тарих ажлыг зохион байгуулах, бусад шаардлагатай мэргэжлийн туслалцаа үзүүлэхэд оршино.” гэсэн зорилгоор үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Орон нутгийн ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- НББ тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Татварын тухай хууль
- Сангийн сайдын тушаал
- Бусад хууль тогтоомж, журам

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Хутаг-Өндөр сумын 2020 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Булган аймаг дахь Төрийн аудитын газар нь 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж алдаа зөрчил илрээгүй байна.

Булган аймаг дахь Төрийн аудитын газар 2020 оны шилэн дансанд хийсэн дотоод аудитаар зөрчил арилгах албан шаардлага, зөвлөмж өгөх алдаа зөрчил илрээгүй.

Санхүүгийн тайлангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн орлого сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн орлогын 69090.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 1381.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хутаг-Өндөр суман дахь Сум дундын ойн ангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 43104.1 мянган төгрөгөөр буюу **66** хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн авто тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилаг эд хогшлын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	17253.4	16335.4	918.0
Үндсэн хөрөнгө	65100.3	21996.2	43104.1
Нийт хөрөнгө	82353.7	38331.6	44022.1
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	27597.4	22942.2	4655.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	27597.4	22942.2	4655.2

Бараа материалын дансны үлдэгдэл 16335.4 мянган төгрөг болж 918.0 мянган төгрөгөөр буурсан нь бараа материал тусгай зориулалтын материал акталсан нь шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Энэ нь бараа материалын тусгай зориулалтын материалын хэрэглээ буурсан байна. Оны эцэст худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгээгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 21996.2 мянган төгрөг болж 13104.1 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгөөс тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил акталсан нь шалтгаалжээ. Хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 4501.3 мянган төгрөгийн эд хогшлыг дахин үнэлж үнэ төлбөргүй орлого хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө акталсан 47605.4 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 22942.2 мянган төгрөг болж 4655.2 мянган төгрөгөөр буурсан нь дахин үнэлгээ болон үндсэн хөрөнгө акталсан шалтгаалжээ. Энэ нь үндсэн хөрөнгөөс акталсан тээврийн хэрэгсэл тоног төхөөрөмжийн хүрэлцээ буурсан байна.

Хутаг-Өндөр суман дахь Сум дундын ойн ангийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 613.5 мянган төгрөгөөр буюу 0.8 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан өмнөх онд нэмэлт дансанд Ойн судалгаа хөгжийн төвөөс бусдаар гүйцэтгүүлэх орлого орсон тайлант онд нэмэлт дансанд орлого төвлөрөөгүй байна. Энэ нь ойн цэвэрлэгээ, судалгаа хийгдээгүй үр дагавартай байна.

Нийт зардал өмнөх оноос 393.5 мянган төгрөгөөр буюу 0.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал засварын зардлаас буурсан байна. Энэ нь цар тахлын улмаас засварын ажил хийгдээгүй байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга байхгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 88601.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 88601.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 26057.8 мянган төгрөгөөр бууруулж /нэмэгдүүлж/ 62544.0 мянган төгрөгөөр баталсан байна. Тээвэр шатахуун, дотоод томилолт, урсгал засвар, хичээл үйлдвэрлэлийн дадлага, нормын хувцас зөөлөн эдлэл зэрэг данснаас зардлыг бууруулж баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагч хэрэгжүүлэхээр төсөл хөтөлбөр, арга хэмжээ үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөөгүй байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 38237.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 30852.9 мянган төгрөг, нийт 69090.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 53649.5 мянган төгрөгийг зарцуулж 15441.01 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 53649.5 мянган төгрөг буюу 77.6 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 4886.5 мянган төгрөгөөр, шимтгэлийн зардлыг 620.2 мянган төгрөгөөр, шуудан холбоо 300.0 мянган төгрөгөөр, дотоод албан томилолт 782.0 мянган төгрөгөөр, хичээл үйлдвэрлэлийн дадлага 247.5 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх арга хэмжээ 236.8 мянган төгрөгөөр, өөрийн орлогоос 8368.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого

Орон нутгийн төсөвт 2020 оны төсвийн тухай хуульд зааснаар 2020 онд 25505.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 30584.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 16.5 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2 Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
Үндсэн үйл ажиллагааны орлого	25505.0	30584.3	5076.3	16.5
Нийт дүн				

Өмнөх оны авлага тус онд дамжиж орж ирснээр төлөвлөгөөг 16.5 хувиар давуулан биелүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар, Засгийн газрын нөөц сан, Засаг даргын нөөц хөрөнгө, дээд шатны төсвийн захирагчаас нэмэлт санхүүжилт аваагүй.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 20 мэдээллээс хугацаандаа оруулсан 20 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй акт албан шаардлага зөвлөмж аваагүй байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0	0	0	0	0	0
Албан шаардлага	0	0	0	0	0	0	0
Зөвлөмж	0	0	0	0	0	0	0
Нийт дүн	0	0	0	0	0	0	0

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 543.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 543.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 543.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил 543.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

1. Өмнөх оны талбай тусгаарлалтын орлого бүрдүүлэлт нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны А/133 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 3.3 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

2. Өмнөх оны талбай тусгаарлалтын орлого бүрдүүлэлт нь Ойгоос мод бэлтгэх журмын 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалт Мод бэлтгэгч талбай тусгаарласан материалыг үндэслэн ойн нөөц ашигласны төлбөр хураамжийг урьдчилан төлж, “Ойгоос мод бэлтгэх эрхийн бичиг”-ийг Ойн ангиас эсхүл сум, дүүргийн Засаг даргын томилсон эрх бүхий албан тушаалтнаас авна” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллуулахаар шийдвэрлэлээ.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Хутаг-Өндөр суман дахь Сум дундын ойн ангийн өмнөх оны талбай тусгаарлалтын авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны А/133 дугаар тушаалын хавсралт Ойгоос мод бэлтгэх журмыг хэрэгжүүлж ажиллаагүй байгаагаас тус авлага үүс ч орлого бүрдүүлэлт бүрэн гүйцэт бүрдэхгүй байна. Мөн батлагдсан орон тоогоор ажиллуулах, өмнөх оны авлагыг санхүүгийн тайланд тусгах зэрэг алдаа зөрчлүүдийг дараа онд давтан гаргахгүй байх арга хэмжээ авч ажиллах шаардлагатай гэж авч үзэх нь зүйтэй.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Бүтэц орон тоотой холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Бүтэц орон тоог 5.5-аар баталсан боловч 3.5 орон тоогоор ажиллаж байна.

1.2. Эрсдэл:

НББ-ийн тухай хуулийн холбогдох дүрэм журам зөрчигдөх, тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх

1.3. Өгсөн зөвлөмж

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийг хэрэгжүүлж батлагдсан орон тоогоор ажиллуулах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

2. Авлагын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Өмнөх оны авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй

2.2. Эрсдэл:

НББ-ийн тухай хуулийн холбогдох дүрэм журам зөрчигдөх, тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх

2.3. Өгсөн зөвлөмж:

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 20165 оны А/133 дугаар тушаалын хавсралтын Ойгоос мод бэлтгэх журмыг 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Хутаг-Өндөр суман дахь Сум дундын ойн ангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			БУА-2021/96/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Хутаг-Өндөр суман дахь Сум дундын ойн анги		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Бүтэц орон тоог 5.5-аар баталсан боловч 3.5 орон тоогоор ажиллаж байна.	0	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Г.Ганхуяг Ц.Булганч имэг
2	Өмнөх оны авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй	0	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Г.Ганхуяг Ц.Булганч имэг
3	Өмнөх оны талбай тусгаарлалтын орлогыг бүрэн оруулах	543.8	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Г.Ганхуяг Ц.Булганч имэг
ДҮН		543.8			

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР

Б.ЭНХТӨР